



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 4/45

Ховд

Г Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1 Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан орон нутгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх, төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх үйлсэд хамт олноо тэргүүлэн ажиллаж буй аймгийн Хөгжимт драмын театрын жүжигчин Д.Хишигтогтох, Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэнд хариуцсан бага эмч С.Цагаанцоож, Ерөнхий боловсролын сургуулийн үйлчлэгч Б.Даваасүрэн, цэцэрлэгийн туслах багш Д.Мөнхжаргал нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Д.Хишигтогтох, С.Цагаанцоож, Б.Даваасүрэн, Д.Мөнхжаргал нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг дээрх байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 00688
D/Zax-A/145-Da